



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2019 оны 09 сарын 23 өдөр

Дугаар 17/11

Номгон

**Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн
корпорацийн үйл ажиллагааны тайланг
хэлэлцсэн тухай**

“Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК нь 2016 онд байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн.

Орон нутгийн төсвөөс жижиг дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор 2017 онд олгосон 560,0 сая төгрөгийг 14 аж ахуйн нэгж, иргэнд олгож, 35 ажлын байрыг, орон нутгийн төсвөөс жижиг дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор 2018 онд олгосон 450,0 сая төгрөг, эргэн төлөлтөөс 74,0 сая төгрөг, нийт 524,0 сая төгрөгийг 129 аж ахуйн нэгж, иргэнд олгож, 51 ажлын байрыг, олгосон зээлүүдийн эргэн төлөлтөөс 2019 онд 160 сая төгрөгийн зээлийг 15 аж ахуйн нэгж, иргэнд олгож 40 ажлын байрыг, нийт 126 ажлын байрыг бий болсон байна.

Мөн үйлдвэрлэл, үйлчилгээний “Ажилсаг” төв дээр 122 ажлын байр бий болгож, 2017 оноос хойш нийт 248 ажлын байр бий болгожээ.

Тус ХХК-иас 2017 оноос хойш олгосон нийт зээлийн 94 хувь нь хэвийн төлөлттэй, 6 хувь нь эргэн төлөлт нь хоцорч байна.

Мөн Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци ХХК нь 3 жилийн хугацаанд өрхийн тариалалтыг дэмжих төслийн хүрээнд 90 өрхийг хашааны газар болон хашаа, гүн өрмийн худаг, эрчим хүч, үр бордоо зэргээр хангаж, жимс жимсгэнэ, төмс хүнсний ногоо тариалахад хяналт тавин ажиллаж байгааг ТЭМДЭГЛЭЭД:

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18.1.2-ын “г”, 19 дүгээр зүйлийн 19.1, 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус ХҮИ хуралдаанаас ТОГТООХ нь:

1. “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК нь 2017-2019 онд жижиг дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор орон нутгийн төсвөөс олгосон 1 тэрбум 10 сая төгрөг, эргэн төлөлтөөс 234,0 сая төгрөгийг 158 аж ахуйн нэгж, иргэнд олгож, 126 ажлын байрыг бий болгосныг сайшаасугай.

1190035

2. Аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д ДААЛГАХ нь:

2.1. Орон нутгийн төсвөөс 2012 оноос хойш зээл авсан ч зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, ашиг орлогоо нэмэгдүүлээгүй, ажлын байр гаргаагүй аж ахуйн нэгжийн гэрээг цуцалж, өр төлбөрийг барагдуулсугай.

2.2. “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-ний үйл ажиллагааны зардлын санхүүжилтийг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлсүгэй.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Т.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА  Ц.ОТГОНБАЯР